



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 9/27

Өмнөговь аймаг, Цогтцэций сум

“Тавантолгой” ХК-ийн нүүрс борлуулах
 үйл ажиллагааны журмыг
 батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 450 дугаар тогтоол, “Тавантолгой” ХК-ийн “Компанийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр бүлэг, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 114 дүгээр зүйлийн 114.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн “Нүүрс борлуулах үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөхийг дурдсугай.
3. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Борлуулалт маркетинг, тээврийн газар/Ч.Гүнждагва/-т даалгасугай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
 БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



П.САЙНЗОРИГ



“Тавантолгой” Хувьцаат компанийн
гүйцэтгэх захирлын 2023 оны 02
дугаар сарын 15.-ны өдрийн *Н.Д.А.*
тушаалын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
НҮҮРС БОРЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Тавантолгой” ХК /Цаашид “компани” гэх/-ийн уурхайгаас олборлосон нүүрсийг иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд худалдан борлууллахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий нөхцөл шаардлага

2.1. Энэ журмын 4 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд нүүрс худалдан авагч иргэн, хуулийн этгээд нь нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах үндсэн нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

- 2.1.1. худалдан авагчийн урьдчилгаа төлбөрийн талаарх мэдээлэл;
- 2.1.2. гэрээний үнэ
- 2.1.3. чанарын үзүүлэлт;
- 2.1.4. нийлүүлэх нүүрсний хэмжээ;
- 2.1.5. худалдааны нөхцөл;
- 2.1.6. бусад нөхцөл.

2.2. Дараах үндсэн шаардлагыг хангасан нүүрс экспортлогч хуулийн этгээдтэй нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулна.

- 2.2.1. гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх санхүүгийн чадамжтай;
- 2.2.2. компанитай өмнө нь байгуулсан гэрээний үүргийн зөрчилгүй;

2.3. Нүүрс худалдах, худалдан авах гэрээний урьдчилгаа төлбөрийг дараах нөхцөлүүдийн аль нэг байдлаар хүлээн авна:

- 2.3.1. дуудлага худалдаа явагдахаас өмнө;

2.3.2. дуудлага худалдаа явагдаж дууссаны дараа шалгарсан компанид хүргүүлсэн мэдэгдлийн дагуу;

2.3.3. нүүрс худалдах, худалдан авах гэрээ шууд байгуулах тохиолдолд худалдан авагчид хүргүүлсэн урьдчилгаа төлбөр төлөх тухай мэдэгдлийн дагуу.

2.4. Энэхүү журмын 2.1.2-т заасан гэрээний үнийг Борлуулалт маркетинг, тээврийн газар улирал бүр боловсруулан гүйцэтгэх захиралд танилцуулна.

2.5. Энэхүү журмын 2.1.3-т заасан чанарын үзүүлэлтийг компанийн Уул уурхай технологийн газар гаргана.

2.6. Энэхүү журмын 2.1.4-т заасан нийлүүлэх нүүрсний хэмжээ нь талуудын урьдчилан тохиролцсон, дуудлага худалдаагаар борлуулсан багц нүүрсний хэмжээ байна.

2.7. Экспортын нүүрс худалдах, худалдан авах гэрээг дараах тохиолдолд байгуулна.

2.7.1. нүүрс худалдан авах дуудлага худалдаагаар шалгарсан компанийн байгуулах;

2.7.2. нүүрс худалдах, худалдан авах гэрээг шууд байгуулах;

2.7.3. цахим биржээр шалгарсан худалдан авагчтай байгуулах

2.8. Экспортын нүүрс худалдах, худалдан авах гэрээнд тусгах төлбөрийн нөхцөл нь дараах байдалтай байна.

2.8.1. Урьдчилгаа төлбөрт нийт гэрээлэх үнийн дүнгийн 30-аас доошгүй хувийг гэрээ байгуулахаас өмнө ажлын 5 өдрийн дотор төлж, гэрээ байгуулснаас хойш нийлүүлэлтийн төлөвлөгөө, хуваарьтай уялдуулан төлбөрийг хуваарийн дагуу төлөх.

2.9. Нүүрс худалдах, худалдан авах гэрээнд олон улсын худалдааны инкотермс нөхцөлийг ашиглах ба шаардлагатай тохиолдолд олон улсын худалдаанд ашиглагддаг нөхцөлийг нүүрс худалдах, худалдан авах гэрээнд тусгах талаар гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

2.10. Нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу үүссэн аливаа нүүрсний чанарын маргааныг талууд хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр тодорхойлж, шийдвэрлэх ба энэ талаар нүүрс худалдах, худалдан авах гэрээнд тодорхой тусгасан байна.

2.11. Компани нь дуудлага худалдаагаар шалгарсан болон гэрээг шууд байгуулах тухай шийдвэр гарсан тохиолдолд барьцаа төлбөрийг байршуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан тухайн хуулийн этгээдтэй нүүрс худалдах,

худалдан авах гэрээг байгуулна. Гэрээний төслийг компанийн борлуулалтын асуудал хариуцсан нэгж боловсруулна.

2.12. Барьцаа төлбөр төлөөгүй, эсхүл барьцаа төлбөрийг төлсөн боловч гэрээ байгуулах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдтэй нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулахгүй.

2.13. Тээврийн асуудал хариуцсан нэгж нь нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу төлөгдсөн төлбөр, ачилт хийх овоолгын чиглэлийг тус тус харгалзан нүүрсний ачилтыг зохион байгуулна.

2.14. Борлуулалтын асуудал хариуцсан нэгж, гэрээний хэрэгжилтийг эхлүүлэх, эерэг баланстай хангуулах, дүгнэж хаахтай холбоотой асуудлыг хариуцна.

2.15. Няглан бодох бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авагч компаниудаас төлсөн урьдчилгаа төлбөр болон үндсэн төлбөрийн мэдээллийг борлуулалтын асуудал хариуцсан нэгжид тухай бүр хүргүүлнэ.

2.16. Сар бүрийн нийлүүлсэн нүүрсний тооцоо /цаашид “Тооцоо нийлэх акт” гэх-/г худалдан авагч компаниудтай харилцан баталгаажуулна.

2.17. Нүүрс худалдах, худалдан авах гэрээ дуусгавар болсон тохиолдолд “гэрээ дүгнэсэн акт”-ыг байгуулна.

Гурав. Дуудлага худалдаагаар гэрээ байгуулах үйл ажиллагаа

3.1. Нүүрс худалдан борлуулах дуудлага худалдааг компанийн борлуулалтын асуудал хариуцсан нэгж нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан, хуулийн этгээдүүдэд нээлттэй, ил тод байдлаар “Экспортын нүүрсний нээлттэй дуудлага худалдааны журам”-ын дагуу зохион байгуулна.

3.2. Дуудлага худалдаанд оролцогч этгээд нь журмын 2.2-т заасан үндсэн шалгуурыг хангасан байна.

3.3. Нүүрс худалдаалах дуудлага худалдааны зард энэхүү журмын 2.4-т заасан үнэ, 2.5-т заасан чанарын үзүүлэлт болон нэмэлт нөхцөлүүдийг борлуулалтын асуудал хариуцсан нэгж боловсруулж, Гүйцэтгэх захирал хянаж, баталгаажуулна.

3.4. Дуудлага худалдааны зарыг нийтэд нээлттэй, ил тод байдлаар компанийн албан ёсны цахим хуудас /tavantolgoi.mn/-д зарлан нийтэлж, компанийтай өмнө нь хамтран ажиллаж байсан, аливаа гэрээний үүргийн зөрчилгүй компаниудад цахим шуудангаар хүргүүлж болно. Зарыг цахим хуудсанд дуудлага худалдаа болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө байршуулна.

3.5. Нүүрс худалдан авах дуудлага худалдаанд оролцогчдоос хүсэлт, дэнчин байршуулсан баримт бусад материал хүлээн авна.

3.5.1. дуудлага худалдааны материалыг компанийн Борлуулалтын асуудал хариуцсан нэгж хүлээн авч баталгаажуулна;

3.5.2. тухайн дуудлага худалдаанд нэг ч этгээд оролцоогүй бол тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцно.

3.6. дуудлага худалдаанд оролцохоор ирүүлсэн этгээдүүдийн материал, бусад шаардлагуудыг хангасан байдлыг дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг/комисс/ тогтооно.

3.7. Нүүрс худалдан борлуулах дуудлага худалдааны ялагч этгээдэд мэдэгдэл хүргүүлнэ.

3.7.1. дуудлага худалдаанд шалгарсан этгээдэд урьдчилгаа төлбөр төлөх болон гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

3.7.2. гэрээний урьдчилгаа төлбөр төлөх тухай болон гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан төлбөрийг байршуулах ба уг хугацаанд байршуулаагүй тохиолдолд гэрээ байгуулахгүй.

3.7.3. Хэрэв тухайн дуудлага худалдааны ялагч нь заасан хугацаанд урьдчилгаа төлбөрийг төлөөгүй тохиолдолд тухайн этгээдтэй гэрээ байгуулахгүй бөгөөд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн шаардлага хангасан дараагийн этгээдэд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж болно.

3.8. Нүүрс худалдах худалдан авах тухай гэрээний хугацааг талууд гэрээгээр тохиролцено.

3.9. Дуудлага худалдааны дэнчин төлсөн оролцогч нь дуудлага худалдаанд шалгараагүй тохиолдолд дэнчинг тухайн оролцогчийн албан хүсэлтэд үндэслэн хуулийн этгээдийн албан ёсны дансанд буцаан шилжүүлэх бөгөөд банкны шилжүүлэг шимтгэлийг оролцогч хариуна.

3.10. Дэнчинг өөр дуудлага худалдаа, багцад шилжүүлэн тооцохгүй бөгөөд бусад компаниудтай байгуулсан гэрээний аливаа төлбөрт шилжүүлэн тооцохгүй.

Дөрөв. Шууд гэрээ байгуулах үйл ажиллагаа

4.1. Гүйцэтгэх захирал өөрийн эрх хэмжээний хүрээнд дор дурдсан нөхцөлүүдэд энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг тусгаж, нүүрс худалдах, худалдан авах гэрээг шууд байгуулна.

4.1.1. давагдашгүй хүчин зүйл, зах зээлийн уналтын үед хэрэгжүүлэх эрсдэлийн төлөвлөгөөний хүрээнд;

4.1.2. шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, гарц нээх борлуулалтын сувгийг тэлэх зорилгоор туршилтын гэрээ байгуулах тохиолдолд.

Тав. Бусад

5.1. Нүүрс худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавихдаа энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

5.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.